



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ  
01 дүгээр сарын 07  
№1 /670/

УНШААГА

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ

**Улсын тэмдэгтийн хураамжийн  
тухай**

МОНГОЛ УЛСЫН  
ХАМГИЙЛЭГЧИЙН  
ЗАРЛИГ

65

**Прокурорын мэргэжлийн  
зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
батлах тухай**

МОНГОЛ УЛСЫН  
ХАМГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

66

**Улсын бүртгэлийн үйлчилгээний  
хөлсний хэмжээг тогтоох тухай**



## ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЭНХЛЭГ

- |  |   |                  |
|--|---|------------------|
| 1.   | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай                           | 1                |
| <b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>  |   |                  |
| 2.   | Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай | Дугаар 258<br>65 |
| <b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b> |   |                  |
| 3.   | Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай | Дугаар 237<br>66 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 11 дүгээр  
сарын 25-ны өдөрУлаанбаатар  
хотУЛСЫН ТЭМДЭГТИЙН  
ХУРААМЖИЙН ТУХАЙ*/Шинэчилсэн найруулга/*НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, төлөх, хураах болон түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай  
хууль тогтоомж**

2.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан

<sup>1</sup> Татварын ерөнхий хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2008 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Улсын тэмдэгтийн хураамж**

3.1.Төрийн эрх бүхий байгууллагаас энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид "тэмдэгтийн хураамж" гэх/ гэнэ.

3.2.Гэрчилгээ, үнэмлэх, паспорт, лиценз, зөвшөөрөл, эрхийн бичгийн үнэ нь тэмдэгтийн хураамжийн дүнд орохгүй.

### **4 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамж төлөгч**

4.1.Тэмдэгтийн хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүж байгаа дараахь этгээд тэмдэгтийн хураамж төлөгч байна:

4.1.1.Монгол Улсын иргэн;

4.1.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

4.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газар, улс төрийн нам, хөдөлгөөн, сан, шашны байгууллага;

4.1.4.гадаад улс дахь Монгол Улсын элчин сайдын яам, консулын газраар дамжуулан үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээд.

### **5 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамж хураах үйлчилгээний төрөл**

5.1.Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

5.1.1.шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх;

5.1.2.арбитрын ажиллагаанд шүүх оролцох;

5.1.3.нотариатын үйлчилгээ үзүүлэх;

5.1.4.иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүгэх;

5.1.5.консулын үйлчилгээ үзүүлэх;

5.1.6.тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгох;

5.1.7.Хувийн хамгаалалтын тухай хуулийн<sup>2</sup> 6.1-д заасан

<sup>2</sup> Хувийн хамгаалалтын тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

5.1.8.сонин, сэтгүүл, радио, телевизийг бүртгэх;

5.1.9.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;

5.1.10.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх;

5.1.11.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн<sup>3</sup> 15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

5.1.12.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн<sup>4</sup> 20.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

5.1.13.Аудитын тухай хуулийн<sup>5</sup> 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрх олгох;

5.1.14.Байгалийн ургамлын тухай хуулийн<sup>6</sup> 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгох;

5.1.15.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн<sup>7</sup> 5.2-т заасан үйл ажиллагаа;

5.1.16.Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн<sup>8</sup> 8.1-д заасан үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох;

5.1.17.Усны тухай хуулийн<sup>9</sup> 11.1.8, 20.3-т заасан усны мэргэжлийн байгууллагад эрх олгох, хугацааг сунгах, мөн хуулийн 23.1-д

<sup>3</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Аудитын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1997 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup> Байгалийн ургамлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup> Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1997 оны 12 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup> Усны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 18 дугаарт нийтлэгдсэн.



заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах эрх олгох;

5.1.18.Ойн тухай хуулийн<sup>10</sup> 12.1.10-т заасны дагуу ойн мэргэжлийн байгууллагад эрх олгох;

5.1.19.Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн<sup>11</sup> 14.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;

5.1.20.Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн<sup>12</sup> 5.2-т заасан зөвшөөрөл олгох;

5.1.21.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн<sup>13</sup> 5.1.4, 5.1.5-д заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ олгох;

5.1.22.Ан агнуурын тухай хуулийн<sup>14</sup> 11.1-д заасан зөвшөөрөл олгох;

5.1.23.Амьтны аймгийн тухай хуулийн<sup>15</sup> 15.2, 17.2, 17.3, 23.1-д заасны дагуу зөвшөөрөл олгох;

5.1.24.Боловсролын тухай хуулийн<sup>16</sup> 20.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох;

5.1.25.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн<sup>17</sup> 8.6-д заасны дагуу гэрчилгээ олгох, мөн хуулийн 9.4, 10.5, 11.3, 17.10, 20.1, 20.3-т заасан үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох;

<sup>10</sup> Ойн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

<sup>11</sup> Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 47 дугаарт нийтлэгдсэн.

<sup>12</sup> Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2000 оны 43 дугаарт нийтлэгдсэн.

<sup>13</sup> Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 43 дугаарт нийтлэгдсэн.

<sup>14</sup> Ан агнуурын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

<sup>15</sup> Амьтны аймгийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

<sup>16</sup> Боловсролын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

<sup>17</sup> Соёлын өвийг хамгаалах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



5.1.26. Эрчим хүчний тухай хуулийн<sup>18</sup> 13, 20 дугаар зүйл, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн<sup>19</sup> 7.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох;

5.1.27. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн<sup>20</sup> 9.4-т заасны дагуу зөвшөөрөл олгох;

5.1.28. Хүнсний тухай хуулийн<sup>21</sup> 9.3-т заасан үйл ажиллагаа;

5.1.29. Хувиргасан амьд организмын тухай хуулийн<sup>22</sup> 6.1, 13.1-д заасан зөвшөөрөл олгох;

5.1.30. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн<sup>23</sup> 15.1-д заасан лиценз олгох;

5.1.31. Эрүүл мэндийн тухай хуулийн<sup>24</sup> 16, 17 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа;

5.1.32. Иргэний нисэхийн тухай хуулийн<sup>25</sup> 11.2.2, 23.1.1, 30.1-д заасан гэрчилгээ, зөвшөөрөл олгох;

5.1.33. Харилцаа, холбооны тухай хуулийн<sup>26</sup> 21.2-т заасан тусгай зөвшөөрөл олгох;

5.1.34. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн<sup>27</sup> 9.1-д заасан олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилттэй

<sup>18</sup> Эрчим хүчний тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>19</sup> Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

<sup>20</sup> Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2004 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

<sup>21</sup> Хүнсний тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

<sup>22</sup> Хувиргасан амьд организмын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

<sup>23</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>24</sup> Эрүүл мэндийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>25</sup> Иргэний нисэхийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

<sup>26</sup> Харилцаа, холбооны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 43 дугаарт нийтлэгдсэн.

<sup>27</sup> Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 21 дугаарт нийтлэгдсэн.



стандартыг бүртгэх, мөн хуулийн 9.2-т заасан зөвшөөрөл олгох, мөн хуулийн 16.4-т заасан тохирлын гэрчилгээ олгох;

5.1.35. мэргэжлийн хяналтын байгууллагаас энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан ажил, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл, гэрчилгээ олгох;

5.1.36. гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгох;

5.1.37. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, тухайн шатны төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл олгох;

5.1.38. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээг бүртгэх;

5.1.39. зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэх;

5.1.40. эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх;

5.1.41. газрыг өмчлүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх зөвшөөрөл олгох, бүртгэх;

5.1.42. Газрын хэвлийн тухай хуулийн<sup>28</sup> 15 дугаар зүйлд заасны дагуу газрын хэвлийг олгох;

5.1.43. баримт бичиг баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгох.

## **6 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох**

6.1. Тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуулиар тогтооно.

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

**7 дугаар зүйл. Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

7.1. Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл,

<sup>28</sup> Газрын хэвлийн тухай хууль-1988 оны Хууль, зарлиг, тогтоолын эмхтгэлийн 11 дугаарт нийтлэгдсэн.

гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

7.1.1.эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамж нь дараахь хэмжээтэй байх:

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/
0-4 000	60 төгрөг
4 001-13 000	60 төгрөг дээр 4 000 төгрөгөөс давсан дүнгийн 2 хувийг нэмнэ.
13 001-65 000	240 төгрөг дээр 13 000 төгрөгөөс давсан дүнгийн 3.5 хувийг нэмнэ.
65 001-650 000	2 060 төгрөг дээр 65 000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ.
650 001-1 300 000	19 610 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувиар нэмнэ.
1 300 001-13 000 000	35 210 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13 000 001-ээс дээш	222 410 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

7.1.2.эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлд 550 төгрөг;

7.1.3.хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутамд 55 төгрөг.

### **8 дугаар зүйл.Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

8.1.Арбитрын ажиллагаанд шүүх оролцоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

8.1.1.арбитрын шийдвэрийг хүвчгүй болгох, баталгаажуулах, гүйцэтгүүлэх тухай хүсэлт шийдвэрлэхэд нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.1 хувь;





8.1.2.Арбитрын тухай хуульд<sup>29</sup> заасан бусад асуудлаар шийдвэр гаргахад нэхэмжлэлийн үнийн дүнгийн 0.05 хувиар.

### **9 дүгээр зүйл. Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

9.1. Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

9.1.1. үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичиг гэрчлэхэд 4 400 төгрөг;

9.1.2. үл хөдлөх эд хөрөнгийн гэрээ гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.03 хувь, бусад хүнд 0.05 хувь;

9.1.3. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.4. эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.5. эд хөрөнгө хөслөх, түрээслэх гэрээ, хэлцэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.6. хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4 400 төгрөг;

9.1.7. хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.8. хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг нотариатаар гэрчлэхэд 2 000 төгрөг;

9.1.9. аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт материал гэрчлэхэд 20 000 төгрөг;

9.1.10. итгэмжлэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.11. баримт бичгийг болон түүний хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 110 төгрөг;

<sup>29</sup> Арбитрын тухай хууль- Төрийн мэдээлэл мөхөөгчийн 2003 оны 20 дугаар нийтлэгдсэн.



9.1.12.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300 төгрөг;

9.1.13.баримт бичигт зурсан гарын үсэг гэрчлэхэд 2 500 төгрөг;

9.1.14.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 110 төгрөг;

9.1.15.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 4 400 төгрөг;

9.1.16.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1 100 төгрөг;

9.1.17.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 550 төгрөг;

9.1.18.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

9.1.19.үнэт цаас өмчлөх эрхийн гэрчилгээ гэрчлэхэд 5 000 төгрөг;

9.1.20.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хувь.

9.1.21.энэ хуулийн 9.1.2-9.1.5-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.02 хувь, 1 000 000 төгрөгөөс давсан дүнгээс 0.01 хувиар хураах.

9.2.Гэрээ, хэлцэлд өөрөөр заагаагүй бол тэмдэгтийн хураамжийг хэлэлцэн тохирогч талууд тэнцүү хувааж төлнө.

### **10 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

10.1.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.1.1.төрснийг бүртгэж, гэрчилгээ олгоход 220 төгрөг;

10.1.2.гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход 300 төгрөг;

10.1.3.гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоход хүн тус бүрээс 550 төгрөг;

10.1.4.гэрлэлт сэргээснийг бүртгэхэд хүн тус бүрээс 440 төгрөг;

10.1.5.эцэг, эх тогтоосныг бүртгэж, гэрчилгээ олгоход 330



төгрөг;

10.1.6.үрчлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход 330 төгрөг;

10.1.7.овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилснийг бүртгэж, гэрчилгээ олгоход 220 төгрөг;

10.1.8.нас барсныг бүртгэж, гэрчилгээ олгоход 330 төгрөг.

10.2.Энэ хуулийн 10.1.1-10.1.8-д заасан баримт бичгийг бүртгэлийг нь анх хөтөлсөн, эсхүл тухайн иргэний оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар дахин олгоход тэмдэгтийн хураамжийг хоёр дахин нэмэгдүүлэн хураана.

10.3.Монгол Улсын иргэний үнэмлэх /цаашид "иргэний үнэмлэх" гэх/ олгох, түүнд тэмдэглэл хийхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.3.1.иргэний үнэмлэх шинээр олгоход 3 300 төгрөг;

10.3.2.иргэний үнэмлэхээ алдаж үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 25 000 төгрөг;

10.3.3.иргэний үнэмлэхийг 25, 45 настай иргэнд сольж олгоход 3 300 төгрөг;

10.3.4.иргэний үнэмлэхэд иргэний оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт хийхэд 200 төгрөг;

10.3.5.оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын харьяат иргэнд цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн оршин суугаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар иргэний үнэмлэх олгоход 3 300 төгрөг.

10.4.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.4.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 5 000 төгрөг, түүний хүчинтэй байх хугацааг сунгахад 2 500 төгрөг;

10.4.2.эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хамт түр хугацаагаар гадаадад зорчих хүүхдэд үндэсний гадаад паспортод хаасаргах үнэмлэх олгоход 2 500 төгрөг;

10.5.Монгол Улсын иргэн гадаадад байхдаа үндэсний гадаад



паспортаа үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгоход Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар дотоодод хураасан хураамжийг хоёр дахин нэмэгдүүлж бусад валютад шилжүүлэн тооцож хураана.

10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгох, түүнийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.6.1.гадаадын иргэнд тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

10.6.2.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

10.6.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солиход 6 000 төгрөг;

10.6.4.гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахад 30 000 төгрөг;

10.6.5.харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, үнэмлэхийн хугацаа сунгахад 4 000 төгрөг;

10.6.6.гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгоход 1 000 төгрөг;

10.6.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд оршин суугаа хаягийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх тухай бүр 500 төгрөг;

10.6.8.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний баримт бичигт гадаадад зорчсон тэмдэглэл хийх тухай бүр 100 төгрөг;

10.6.9. Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгоход 500 төгрөг;

10.6.10. гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргахад 500 төгрөг;

10.6.11.гадаадын иргэн оршин суух үнэмлэхээ алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд шинээр олгоход 5 000 төгрөг;



10.6.12.гадаадын иргэнийг бүртгэхэд 100 төгрөг;  
10.6.13.гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1 000 төгрөг ;

10.6.14.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орон нутагт явахад зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 100 төгрөг;

10.6.15.нэг удаагийн орох болон гарах-орох виз олгоход 45 000 төгрөг;

10.6.16.хоёр удаагийн орох болон гарах-орох виз олгоход 67 500 төгрөг;

10.6.17.зургаан сарын олон удаагийн виз олгоход 105 000 төгрөг;

10.6.18.зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 210 000 төгрөг;

10.6.19.дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 30 000 төгрөг;

10.6.20.дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход 60 000 төгрөг;

10.6.21.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах-орох виз олгоход 15 000 төгрөг;

10.6.22.нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгах, визийг шилжүүлэн олгоход 15 000 төгрөг;

10.6.23.визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад 22 500 төгрөг, дараагийн хоног тутамд 3 000 төгрөг;

10.6.24. визийн ангилал өөрчлөхөд 30 000 төгрөг;

10.6.25.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 750 000 төгрөг;

10.6.26.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл өгч, гэрчилгээний хугацааг сунгахад 300 000 төгрөг;

10.6.27.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход 50 000 төгрөг;

10.6.28.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах,



иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхэд 50 000 төгрөг.

10.7.Виз олгох үйлчилгээг яаралтай буюу ажлын 8 цагт багтаан олгох, хилийн боомт дээр олгох тохиолдолд хураамжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн хураана.

### **11 дүгээр зүйл.Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

11.1.Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.1.1.төрснийг бүртгэж, гэрчилгээ олгоход 2 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.2.гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход 3 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.3.гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоход хүн бүрээс 10 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.4.гэрлэлт сэргээснийг бүртгэхэд хүн тус бүрээс 4 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.5.үрчлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход 2 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.6.эцэг, эх тогтоосныг бүртгэж, гэрчилгээ олгоход 1 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.7.нас барсныг бүртгэж, гэрчилгээ олгоход 3 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.8.овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсныг бүртгэж, гэрчилгээ олгоход 1 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.2.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.2.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 12 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.2. дипломат, албан паспорт олгоход 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.3.Монгол Улсад буцах үнэмлэх олгоход 22 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.4.үндэсний гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад 2 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.5.хүүхдийн үнэмлэх олгоход 2 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.6.гэмтээсэн, үрэгдүүлсэн дипломат паспорт дахин олгоход 60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.7.гэмтээсэн, үрэгдүүлсэн албан паспорт дахин олгоход 50 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.3.Монгол Улсад зорчих гадаадын иргэнд виз олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.3.1.орох виз олгоход тус бүр 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.2.гарах-орох виз олгох тус бүр 38 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.3.дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход тус бүр 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.4.дамжин өнгөрөх хоёр удаагийн виз олгоход тус бүр 45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.5.зургаан сарын олон удаагийн виз олгоход 97 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.6.зургаан сарвас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 195 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.7.визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад 25 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют, дарлагчийн хоног тутамд 3 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;



11.3.8.нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгахад 15 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.3.9.визийн ангилал өөрчлөхөд 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.4.Консулын үйлчилгээг яаралтай үзүүлэх тохиолдолд энэ хуулийн 11.3-т заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг ажлын 8 цагийн дотор бол хоёр дахин нэмэгдүүлж, амралт, баяр ёслолын өдөр бол гурав дахин нэмэгдүүлэн хураана.

11.5.Консулын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.5.1.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 18 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.2.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасныг гэрчлэхэд 7 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.3.эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, дүрэм гэрчлэхэд 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.4. Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл /гэрээ, гэрээслэл, итгэмжлэл зэрэг/-ийг гэрчлэхэд 52 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.5.баримт бичигт консулын баталгаа гаргахад 1 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.6.баримт бичгийг болон баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 1 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.7.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.8.баримт бичигт зурсан гарын үсгийг гэрчлэхэд 2 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.9.гэрчлөгдсөн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 200 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;



11.5.10.үйлчилүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 7 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.11.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 16 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.12.үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичгийг гэрчлэхэд баримт бичигт тусгагдсан үнийн дүнгийн 0.06 хувиар;

11.5.13.үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.035 хувиар, бусад хүнд үнийн дүнгийн 0.055 хувиар;

11.5.14.энэ хуулийн 11.5.1-11.5.3, 11.5.7-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.025 хувиар, 1 000 000 төгрөгөөс давсан хэсгээс 0.015 хувиар нэмэгдүүлж;

11.5.15.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хувиар;

11.5.16.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм гэрчлэхэд хуудас тутмаас 20 цент буюу түүнтэй тэнцэх бусад валют.

11.6.Өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.6.1. 1000 хүртэл ам.доллартай тэнцэх дүнтэй бол 15 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.2. 1 001-10 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 23 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.3. 10 001-25 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.4. 25 001-100 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 37 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.5. 100 001-300 000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.6. 300 001 болон түүнээс дээш ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.7. өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 100 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.6.8. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд 7 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

**12 дугаар зүйл.Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хурааж тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

12.1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.1.1.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 550 төгрөг;

12.1.2.автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1 650 төгрөг;

12.1.3.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 20 000 төгрөг;

12.1.4.өөрөө явагч хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1 650 төгрөг.

12.2.Автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.2.1.автомашин дугаар олгоход 2 200 төгрөг;

12.2.2.өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 1 650 төгрөг;



12.2.3.мотоциклийн улсын дугаар олгоход 1 100 төгрөг;

12.2.4.автомашин, өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн болон мотоциклийн улсын дугаарыг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 40 000 төгрөг.

12.3.Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа орон нутгийн байгууллагад бүртгэхэд 500 төгрөгний тэмдэгийн хураамж хураана.

12.4.Агаарын хөлөг болон усан онгоцыг бүртгэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, аэродром, усан /хөлөг/ онгоцыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгийн хураамж хураана:

12.4.1.Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 44 000 төгрөг;

12.4.2.гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэний өмчлөлд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын иргэний агаарын тээвэрт ашиглахаар гэрээ байгуулсан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэж, үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 500 000 төгрөг;

12.4.3.энэ хуулийн 12.4.2-т заасан гэрчилгээний хугацааг сунгахад 400 000 төгрөг;

12.4.4.агаарын хөлгийг ашиглалтаас хасах, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулаагүй гадаадын байгууллагад болон Монгол Улсын харьяат бус бөгөөд тус улсад оршин суудаггүй хүнд худалдсан, шилжүүлсэн тохиолдолд улсын бүртгэлээс хасахад 30 000 төгрөг;

12.4.5.аэродромыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 44 000 төгрөг;

12.4.6.хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэх, тухайн хөлөг онгоцонд Монгол Улсын төрийн далбааг мандуулах, хөвөө эрхийн гэрчилгээ олгоход 44 000 төгрөг;

12.1.7.дэдлэг өлгөцны улсын бүртгэлийн гэрчилгээ, тээх хугацааг сунгахад тус бүрд 40 000 төгрөг;



12.4.8.дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар, гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

12.4.9.төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 60 000 төгрөг;

12.4.10.гадаад улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцыг дангаар түрээслэх гэрээгээр эзэмшиж байгаа, уг хөлөг онгоц нь зохих мэргэжил, боловсрол эзэмшсэн, дадлага туршлагатай багаар хангагдсан түүнийг нэг удаагийн аяллын гэрээг үргэлжлүүлэх хугацаанд дангаар түрээслэсэн хөлөг гэж үзэж Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 37 500 000 төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

**13 дугаар зүйл. Галт зэвсэг худалдах, эзэмших, улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, бүртгэх, харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

13.1. Галт зэвсэг худалдах, эзэмших, улсын хилээр нэвтрүүлэх, тээвэрлэх, бүртгэх, харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

13.1.1. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөлд байгаа галт зэвсгийг бүртгэж, гэрчилгээ олгоход нэгж бүрээс 5 000 төгрөг;

13.1.2. галт зэвсгийн шилжилтийг бүртгэж гэрчилгээ олгоход 2 500 төгрөг;

13.1.3. ан агнах, уралдаан тэмцээнд оролцох зорилгоор ашиглах гадаадын иргэний галт зэвсгийг бүртгэж улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн хуудас олгоход 225 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

13.1.4. галт зэвсэг үйлдвэрлэх, нийтэд худалдах эрхийн тусгай зөвшөөрөл олгоход 750 000 төгрөг;

13.1.5. галт зэвсэг худалдах төв салбараас орон нутагт салбар байгуулах тусгай зөвшөөрөл олгоход салбар бүрт 240 000 төгрөг;

13.1.6. хуулийн этгээдэд нийтэд худалдах зориулалтаар галт зэвсэг болон сумыг улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгарсан этгээдэд олгоход 500 000 төгрөг.



13.2.Хувийн харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

13.2.1.хувийн харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгоход 75 000 төгрөг;

13.2.2.хувийн хамгаалалт эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгахад тус бүрд 75 000 төгрөг

**14 дүгээр зүйл.Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

14.1.Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

14.1.1. сонин, сэтгүүлийг бүртгэж, гэрчилгээ олгоход 22 000 төгрөг;

14.1.2. олон нийтийн болон хувийн радиог бүртгэхэд 32 000 төгрөг;

14.1.3. олон нийтийн болон хувийн телевизийг бүртгэхэд 100 000 төгрөг;

14.1.4. кабелийн телевизийг бүртгэхэд 120 000 төгрөг;

14.1.5. сонин, сэтгүүл, радио, телевиз, кабелийн телевизийн бүртгэлд өөрчлөлт орсныг бүртгэхэд 20 000 төгрөг.

**15 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.1.1.нөхөрлөл, компанийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 22 000 төгрөг;

15.1.2.хоршоог бүртгэж, гэрчилгээ олгоход 13 200 төгрөг;

15.1.3.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг бүртгэж, гэрчилгээ олгоход 35 000 төгрөг;

15.1.4.боловсролын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 15 000 төгрөг;



15.1.5.эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 20 000 төгрөг;

15.1.6.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

15.1.7.хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацааг нь сунгахад 2 200 төгрөг;

15.1.8.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгох тохиолдолд анх хураасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлж;

15.1.9.улсын бүртгэлийн жагсаалтаас лавлагаа олгоход 2 000 төгрөг.

15.2.Улс төрийн нам, шашны болон төрийн бус байгууллага, сан, холбоо, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.2.1.улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 150 000 төгрөг;

15.2.2.улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 50 000 төгрөг;

15.2.3.шашны байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгоход 200 000 төгрөг;

15.2.4.төрийн бус байгууллага, сан, холбоо хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход 22 000 төгрөг.

**16 дугаар зүйл.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

16.1.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.1.1.салбар, төлөөлөгчийн газар, нэгж ажиллуулахад 1 100 000 төгрөг;

16.1.2.салбар, төлөөлөгчийн газрын ажиллах хугацааг сунгахад 750 000 төгрөг;



16.1.3.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад 750 000 төгрөг;

16.1.4.гэрчилгээний хугацааг сунгахад 75 000 төгрөг;

16.1.5.гэрчилгээг сольж олгоход анх олгоход хураасан үндсэн хураамж дээр 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр;

16.1.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд түүний салбар, төлөөлөгчийн газрын гэрээ, дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэхэд 35 000 төгрөг;

16.1.7.гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах зөвшөөрөл олгоход 2 800 000 төгрөг;

16.1.8.гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход 1 800 000 төгрөг.

**17 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

17.1.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

17.1.1.банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000 төгрөг;

17.1.2.мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

17.1.3.зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 750 000 төгрөг;

17.1.4.телбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 45 000 төгрөг;

17.1.5.өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 185 000 төгрөг;

17.1.6.гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 175 000 төгрөг;

17.1.7.үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах.

худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

17.1.8.үнэт зүйл хадгалах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

17.1.9.гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

17.1.10.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

17.1.11.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

17.1.12.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг.

17.1.13.гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл олгоход 3 200 000 төгрөг;

17.1.14.гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл олгоход 1 200 000 төгрөг.

17.1.15.энэ хуулийн 17.1.1-17.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 200 000 төгрөг;

17.1.16.хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 130 000 төгрөг.

**18 дугаар зүйл.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

18.1.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.1.1.арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

18.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээхэд 500 000 төгрөг;





18.1.3.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

18.1.4.актуарчийн эрх олгоход 350 000 төгрөг;

18.1.5.даатгагчид өөрийн салбар төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

18.1.6.даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авахад 100 000 төгрөг;

18.1.7.гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 4 500 000 төгрөг.

18.2.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.2.1.даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгоход 45 000 төгрөг;

18.2.2.даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл олгоход 65 000 төгрөг;

18.2.3.даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгоход 85 000 төгрөг.

18.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.3.1.зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

18.3.2.факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

18.3.3.хөрөнгө сруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

18.3.4.төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх



тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

18.3.5.төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.6.цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.7.гадаад валютын үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

18.3.8.итгэлцлийн үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.9.богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.10.үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.11.банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд өөрийн салбар, төлөөлөгчийн газар, нэгжийг нээх зөвшөөрөл авахад /нэгж бүрт/ 260 000 төгрөг, банк бус санхүүгийн байгууллагын ажиллах зөвшөөрлийн хугацааг сунгах, баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхэд тухай бүр 10 000 төгрөг;

18.3.12.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

18.3.13.банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг олгоход 60 000 төгрөг;

18.3.14.үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, бүртгэхэд 33 000 төгрөг;

18.3.15.үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

18.3.16.үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

18.3.17.үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

18.3.18.андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 145 000 төгрөг;

18.3.19.хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

18.3.20.банжнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

18.3.21.компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

18.3.22.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

18.3.23.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

18.3.24.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг.

**19 дүгээр зүйл. Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

19.1.Санхүү, эдийн засгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

19.1.1.нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

19.1.2.аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

19.1.3.үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 500 000 төгрөг;

19.1.4.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл олгоход 600 000 төгрөг;

19.1.5.хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 240 000 төгрөг;

19.1.6.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 850 000 төгрөг;

19.1.7.гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 4 500 000 төгрөг;

19.1.8.Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад тэнцсэн иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, түүний хугацааг сунгахад 20 000 төгрөг.

**20 дугаар зүйл.Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

20.1.Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

20.1.1.шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

20.1.2.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

20.1.3.нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

20.1.4.Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээлэл-ээс бусад/ хэвлэх тусгай зөвшөөрөл олгоход хэвлэх эх материалын хуудас тутамд 400 төгрөг;

20.1.5.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 150 000 төгрөг;

20.1.6.тамга, тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 200 000 төгрөг.



**21 дүгээр зүйл. Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

21.1. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

21.1.1. байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 8 000 000 төгрөг;

21.1.2. стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 26 000 000 төгрөг;

21.1.3. химийн хортой болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах тусгай зөвшөөрөл олгоход 75 000 000 төгрөг;

21.1.4. тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 000 төгрөг;

21.1.5. байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

21.1.6. озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

21.1.7. нэн ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 45 000 төгрөг;

21.1.8. ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 25 000 төгрөг;

21.1.9. ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 800 төгрөг;

21.1.10. эрх бүхий байгууллагаас импортоор оруулах, экспортлохыг зөвшөөрсөн ургамалд үзлэг шалгалт хийж хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход килограмм тутамд 150 төгрөг;



21.1.11. ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тусгай хэрэгцээний мэдээллээр хангах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 30 000 төгрөг;

21.1.12. 100 /нэг зуу/ шоометрээс дээш ус ашиглах зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгахад 200 000 төгрөг;

21.1.13. усны судалгаа, хайгуул хийх мэргэжлийн байгууллагын эрх олгоход 850 000 төгрөг;

21.1.14. усны болон ойн мэргэжлийн байгууллагын эрх олгоход эрх олгосон жил тутамд 50 000 төгрөг;

21.1.15. усны мэргэжлийн байгууллагын эрхийн хугацааг сунгахад 5 жил тутамд 300 000 төгрөг;

21.1.16. аюултай хог хаягдлыг ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 3 785 000 төгрөг;

21.1.17. аюултай хог хаягдлыг экспортлох зөвшөөрөл олгоход 1 500 000 төгрөг;

21.1.18. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай конвенцийн хавсралтад орсон ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай, тэнгисээс олборлон оруулах зөвшөөрөл, гэрчилгээ олгоход аж ахуйн нэгж, байгууллагаас 1 850 000 төгрөг, иргэнээс 650 000 төгрөг;

21.1.19. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын Амьтны аймгийн тухай хуулийн<sup>30</sup> 17.3-т заасан амьтны цуглуулгыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 750 000 төгрөг;

21.1.20. хувиргасан амьд организм экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгоход 3 000 000 төгрөг;

21.1.21. хувиргасан амьд организмыг үйлдвэрлэх эрх олгоход 6 000 000 төгрөг, хувиргасан амьд организмыг гарган авах, туршилт явуулах эрх олгоход 120 000 төгрөг.

<sup>30</sup> Амьтны аймгийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



**22 дугаар зүйл. Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

22.1.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

22.1.1.их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах зөвшөөрөл олгоход 370 000 төгрөг;

22.1.2.мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

22.1.3.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

22.1.4.дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

22.1.5.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

22.1.6.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

22.1.7.боловсролын магадлан итгэмжлэл олгоход 260 000 төгрөг;

22.1.8.магадлан итгэмжлэлийн хугацааг сунгахад 85 000 төгрөг;

22.1.9.түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 15 000 төгрөг;

22.1.10.уран бүтээл, цуглуулгын зүйлс ба түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

22.1.11.эцэс "уугийн" 22.1.10-д эцэсэд эцэсээрлийн хугацааг сунгах, зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад 200 000 төгрөг;

22.1.12.Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл олгоход 465 000 төгрөг;

22.1.13.улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл олгоход 65 000 төгрөг;

22.1.14.түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагаа, судалгаа хийх зөвшөөрөл олгоход 460 000 төгрөг;

22.1.15.хот, суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 85 000 төгрөг;

22.1.16.төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг гарцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор хоёр жилээс дээшгүй хугацаагаар улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, шаардлагатай бол хугацааг сунгахад 640 000 төгрөг;

22.1.17.хувийн өмчид байгаа түүх, соёлын хосгүй үнэт болон үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөгч өөрөө язгуур ахуйн хэрэглээний зориулалтаар улсын хил нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 240 000 төгрөг;

22.1.18.түүх, соёлын дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр хоёр жилээс дээшгүй хугацаагаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 600 000 төгрөг.

**23 дугаар зүйл.Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

23.1.Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.1.1.эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах зөвшөөрөл олгоход 1МВт тутамд 300 000 төгрөг;

23.1.2.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн



зохицуулалт хийх, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 1 000 000 төгрөг;

23.1.3. туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ хийх зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг.

23.2. Зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.2.1. 115 градусын температуртай 0.7-35.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

23.2.2. 116 градусын температуртай 35.0-70.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

23.2.3. 117 градусын температуртай 70.0-100.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

23.2.4. 118 градусын температуртай 100.0 кгх/см кв-аас дээш даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

23.2.5. 115-250 градусын температуртай 0.7-16.0 кг/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

23.2.6. 250-350 градусын температуртай 16.0-40.0 кгх/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

23.2.7. 350-450 градусын температуртай 80.0 кгх/см кв-аас дээш даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

23.2.8. 450 градусаас дээш температуртай 40.0-80.0 кгх/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

23.2.9. 0.4/10 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах



гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

23.2.10. 15/35 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

23.2.11. 110 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

23.2.12. 220 кВ. цахилгаан эрчим хүчний дамжуулах гол шугам, шугам угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

23.2.13. 400 кВ-аас дээш тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамын зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг.

23.3.Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр олгох тусгай зөвшөөрөлд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.3.1.сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих этгээдэд эрчим хүчний барилга, байгууламж барих зөвшөөрөл олгоход 1кВт тутамд 3 000 төгрөг;

23.3.2.сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

23.3.3.бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход 75 000 төгрөг;

23.3.4.бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл олгоход 60 000 төгрөг.

**24 дүгээр зүйл.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

24.1.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



24.1.1.Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

24.1.2.зуучлах зөвшөөрлийг сунгахад 200 000 төгрөг;

24.1.3.гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад зуучлах зөвшөөрөл олгоход 8 000 000 төгрөг;

24.1.4.Засгийн газраас гадаадын иргэнд улсын онц чухал объект гэж тогтоосон газар ажиллах зөвшөөрөл олгоход 850 000 төгрөг.

**25 дугаар зүйл.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

25.1.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

25.1.1.одон, медаль үйлдвэрлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

25.1.2.аж ахуйн нэгж, байгууллага хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдах зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас олгоход 50 000 төгрөг;

25.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас олгоход тухай бүр 250 00 төгрөг;

25.1.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгоход 3 250 000 төгрөг;

25.1.5.ашигт малтмал хайх, ашиглахтай холбогдсон үйл ажиллагаанд дор дурдсан хэмжээгээр:

№	Үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөг/	
		Ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл эзэмшигч	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч
1	Тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүсч гаргасан өргөдлийг хянан үзэх	250 000	1 000 000

2	Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай өргөдлийг хянан үзэх	1 500 000	7 000 000
3	Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
4	Тусгай зөвшөөрлийг барьцаалах өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
5	Барьцааны гэрээний дагуу тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг хянан үзэх	1 000 000	2 000 000
6	Талбай буцааж хүлээлгэн өгөх өргөдлийг хянан үзэх	50 000	500 000
7	Хилийн маргааныг шийдвэрлүүлэх тухай өргөдлийг хянан үзэх	250 000	500 000
8	Үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох	200 000	250 000
9	Нэмэлт өргөдлийг хянан үзэх	200 000	1 000 000

25.1.6.тамхи импортлох тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад 14 000 000 төгрөг;

25.1.7.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

25.1.8.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

25.1.9.үкэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг.

25.1.10.газрын тосны үйл ажиллагаа эрхлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураах:



25.1.10.а.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 000 төгрөг;

25.1.10.б.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 000 төгрөг;

25.1.10.в.газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

25.1.10.г.эрэл хайгуулын хугацааг сунгахад жилд 4 000 000 төгрөг;

25.1.10.д.ордыг ашиглах хугацааг сунгахад 5 000 000 төгрөг.

**26 дугаар зүйл.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

26.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.1.1.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 7 500 000 төгрөг;

26.1.2.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 4 500 000 төгрөг;

26.1.3.спирт үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 200 000 000 төгрөг;

26.1.4.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 100 000 000 төгрөг;

26.1.5.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 50 000 000 төгрөг;

26.1.6.таримал ургамлын үр үйлдвэрлэх зөвшөөрөл олгоход 125 000 төгрөг;

26.1.7.малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх,



импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 600 000 төгрөг;

26.1.8. малын өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

26.1.9. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

26.1.10. шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан мал, амьтны эм, үр, үр хөврөлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах, энэ хуулийн 26.2-т зааснаас бусад үржлийн мал, амьтныг гадаадад гаргах тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

26.1.11. улсын болон бүс нутгийн хэмжээнд мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

26.1.12. ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

26.2. Үржлийн мал экспортод гаргах лиценз олгоход толгой тутмаас дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.2.1. цэвэр үүлдрийн адуу 15 000 төгрөг;

26.2.2. үржлийн бусад адуу 12 000 төгрөг;

26.2.3. цэвэр үүлдрийн үржлийн үхэр 16 500 төгрөг;

26.2.4. үржлийн бусад үхэр 15 000 төгрөг;

26.2.5. цэвэр үүлдрийн гахай 18 000 төгрөг;

26.2.6. хонь 12 500 төгрөг;

26.2.7. ямаа 10 000 төгрөг;

26.2.8. тэмээ 30 000 төгрөг.

26.3. Малын үр хөврөл, бичил биетний өсгөвөр экспортод гаргахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.3.1. бухын үр 25 000 төгрөг;

26.3.2. үржлийн мал, амьтны үр /бухын үр орохгүй/ ийлдэс 35 000 төгрөг;

26.3.3. үржлийнхээс бусад мал, амьтны үр хөврөл 30 000 төгрөг;

26.3.4. мал эмнэлгийн зориулалттай вакцин 130 000 төгрөг;

26.3.5.зайлшгүй хяналтанд байх эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай эд эрхтэн, донорын цус, бичил биетний өсгөөр 125 000 төгрөг.

**27 дугаар зүйл.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

27.1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.1.1.эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез, ортопед үйлдвэрлэл, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 110 000 төгрөг;

27.1.2.мансууруулах үйлчилгээ бүхий ургамал ашиглаж эм бэлтгэх болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис тэдгээрийн угтвар бодисын үйлдвэрлэл, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 12 000 000 төгрөг;

27.1.3.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл олгоход 6 600 000 төгрөг, хугацааг сунгахад 1 500 000 төгрөг;

27.1.4.улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

27.1.5.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эмчилгээний гоо заслын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг;

27.1.6.эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 400 000 төгрөг;

27.1.7.энэ хуулийн 27.1.6-д заасан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 125 000 төгрөг;

27.1.8.энэ хуулийн 27.1.6-д заасан тусгай зөвшөөрлийг дахин олгоход 200 000 төгрөг;

27.1.9.эрүүл мэндийн магадлан итгэмжлэл олгоход 250 000 төгрөг;



27.1.10.биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

27.1.11.өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга турших, нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг.

27.2.Өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.2.1.ургамлын хорио цээрийн гэрчилгээ олгоход тонн тутамд 25 000 төгрөг;

27.2.2.импортын лиценз олгоход 12 500 төгрөг;

27.2.3.экспортын лиценз олгоход 12 500 төгрөг.

27.3.Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг хураана.

27.4.Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.4.1.анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид хоёр жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 10 000 төгрөг;

27.4.2.мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон энэ хуулийн 27.4.1-д заасан зөвшөөрлөөр хоёр жил ажилласан эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 5 000 төгрөг;

27.4.3.анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эмчлэх, эм барих, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгоход 400 000 төгрөг.



**28 дугаар зүйл.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

28.1.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

28.1.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

28.1.2.барилгын ажил гүйцэтгэх, барилга угсралтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 500 000 төгрөг;

28.1.3.барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

28.1.4.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход 350 000 төгрөг;

28.1.5.нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх зөвшөөрөл олгоход 2 400 000 төгрөг;

28.1.6.кадастрын зураглал хийх зөвшөөрөл олгоход 450 000 төгрөг;

28.1.7.цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000 төгрөг;

28.1.8.нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

28.1.9.цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалттай байгууламж, 16–гаас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, тухайн барилга байгууламжид зөвшөөрөл олгоход 2 400 000 төгрөг;

28.1.10.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

28.1.11.газрын кадастрын судалгаа хийх зөвшөөрөл олгоход 1 500 000 төгрөг;

28.1.12.хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн төсөл,



бус нутгийн хөгжлийн төсөв, хот, тосгоны хөгжлийн өрөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслийг боловсруулах мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл олгоход 900 000 төгрөг.

**29 дүгээр зүйл.Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

29.1.Зам, тээвэр, аялал, жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

29.1.1.төмөр замын суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

29.1.2.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

29.1.3.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 16 000 000 төгрөг;

29.1.4.авто зам, авто замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрөл олгоход 3 000 000 төгрөг;

29.1.5.авто зам засварлах, арчлах зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

29.1.6.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 280 000 төгрөг;

29.1.7.улс хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 4 000 000 төгрөг;

29.1.8.хот хоорондын нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

29.1.9.иргэний агаарын хөлгийг Монгол Улсад бүтээх, түүнд өөрчлөлт, сайжруулалт хийх тусгай зөвшөөрөл олгоход 2 578 000 төгрөг;

29.1.10.аэродром, нисэх буудлын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 752 000 төгрөг;

29.1.11.агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 14 000 000 төгрөг;

29.1.12.агаарын хөлгийн засвар, үйлчилгээ хийх зөвшөөрөл олгоход 4 580 000 төгрөг;

29.1.13.иргэний нисэхийн багц дүрмээр аюулгүйн бүсийн нутаг дэвсгэрт барилга байгууламж барих, мал, гэрийн тэжээвэр ан амьтдыг байрлуулах зэрэг аливаа ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 2 400 000 төгрөг;

29.1.14.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоход ашиглалтын хугацааны жил тутамд 200 000 төгрөг;

29.1.15.захилгат нислэг үйлдэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг агаарын хөлгийн жингээс хамааруулж, нислэг үйлдэх тухай бүрт хүнд жингийн хөлөг онгоцонд 2 000 000 төгрөг, дунд жингийн хөлөг онгоцонд 1 000 000 төгрөг, нисдэг тэрэг/хөнгөн/-т 500 000 төгрөг;

29.1.16.Монгол Улсын\* болон гадаад улсын агаарын хөлөгт олон улсын тогтмол нислэг үйлдэх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

29.1.17.усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

29.1.18.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 700 000 төгрөг;

29.1.19.дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 4 000 000 төгрөг;

29.1.20.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 450 000 төгрөг.

**30 дугаар зүйл.Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

30.1.Харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ байгуулах, түүний ашиглалттай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



30.1.1.мэдээлэл холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.2.мэдээлэл холбооны бүсийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.3.мэдээлэл холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.4.мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 2 250 000 төгрөг;

30.1.5.үүрэн холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 2 250 000 төгрөг;

30.1.6.радио, телевизийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.7.шуудан холбооны хотын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.8.шуудан холбооны бүсийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.9.шуудан холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.10.улс хоорондын шуудангийн сүлжээ байгуулах, түүнийг ашиглахад 1 250 000 төгрөг;

30.1.11.радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 125 000 төгрөг.

30.2.Харилцаа, холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.2.1.улс хоорондын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 1 500 000 төгрөг;

30.2.2.бүсийн телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 1 000 000 төгрөг;

30.2.3.хотын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 800 000 төгрөг;



30.2.4.хот хоорондын телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 600 000 төгрөг;

30.2.5.үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 2 200 000 төгрөг;

30.2.6.утасгүй телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд /WLL8 PHS гэх мэт/ 2 100 000 төгрөг;

30.2.7.телевизийн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 1 500 000 төгрөг;

30.2.8.кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэхэд /CATV MMDS гэх мэт/ 2 000 000 төгрөг;

30.2.9.радио өргөн нэвтрүүлгийг нэвтрүүлэх, дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 100 000 төгрөг;

30.2.10.интернет телефон холбооны үйлчилгээ эрхлэхэд 1 250 000 төгрөг;

30.2.11.улс хоорондын суваг, шугам түрээслүүлэх үйлчилгээ эрхлэхэд 2 500 000 төгрөг;

30.2.12.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 120 000 төгрөг;

30.2.13.шуудангийн үндсэн үйлчилгээ эрхлэхэд 80 000 төгрөг;

30.2.14.шуудангийн нэмэлт үйлчилгээ эрхлэхэд 70 000 төгрөг;

30.2.15.улс хоорондын шуудангийн илгээлтийн үйлчилгээг чиглэсэн маршрутаар эрхлэхэд 75 000 төгрөг.

30.3.Харилцаа холбооны үйлчилгээг дамжуулан хүргэх үйлчилгээг эрхлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.3.1.сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэхэд 180 000 төгрөг;

30.3.2.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 120 000 төгрөг;

30.3.3.интернетийн үйлчилгээг дахин дамжуулан хүргэхэд 250 000 төгрөг;

30.3.4.дотоод хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэхэд 250 000 төгрөг.

30.4.Интернетийн үйлчилгээ эрхлэхэд 300 000 төгрөг хураана.

30.5.Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар, угсралтын ажил, үйлчилгээ эрхлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.5.1.дотоод холбооны сүлжээний суурилуулалт, засварын үйлчилгээ эрхлэхэд 800 000 төгрөг;

30.5.2.холбооны кабель шугамын суурилуулалт, засвар, угсралтын ажил үйлчилгээ эрхлэхэд 900 000 төгрөг;

30.5.3.барилгын дотор холбооны монтаж, угсралтын үйлчилгээ эрхлэхэд 1 100 000 төгрөг;

30.5.4.цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсрах, суурилуулах үйлчилгээ эрхлэхэд 1 500 000 төгрөг;

30.6.Мэдээлэл, лавлагааны зориулалттай тусгай дугаарын менежментийн үйлчилгээ эрхлэхэд 2 850 000 төгрөг хураана.

30.7.Дотоодын хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 550 000 төгрөг хураана.

30.8.Тусгай зөвшөөрлийн хугацаа болон нэгдсэн бүртгэл сунгахад жил тутамд 500 000 төгрөг хураана.

**31 дүгээр зүйл.Стандартчилал, хэмжил зүйн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

31.1.Стандартчилал, хэмжил зүйн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

31.1.1.олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилттэй стандартыг бүртгэхэд 85 000 төгрөг;



31.1.2. шинэ технологи, бүтээгдэхүүн эзэмшиж байгаа этгээдэд Монгол Улсад хэрэглэхээр зааснаас өөр стандарт, аргачлал, зааврыг нэг жил хүртэл хугацаагаар хэрэглэх түр зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

31.1.3. тохирлын гэрчилгээ олгоход 45 000 төгрөг;

31.1.4. хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг.

### **32 дугаар зүйл. Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

32.1. Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

32.1.1. хот, тосгон, түүний хэсэг, орон сууц, үйлдвэр, үйлчилгээний цогцолборт шаардагдах дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан эрчим хүч, холбоожуулалт, радио, дохиоллын холболтын эх үүсвэрийн шийдэл, барилгын үйлдвэрлэлд тавигдах шаардлагын дагуу байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын албанаас дүгнэлт гаргахад 180 000 төгрөг;

32.1.2. барилга байгууламжийг өргөтгөх болон хийц бүтэц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлахад зөвшөөрөл олгоход 240 000 төгрөг;

32.1.3. амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох гэрчилгээ олгоход 10 000 төгрөг;

32.1.4. мал, ан амьтан, шувууны болон түүхий мах, өөх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн, загас, бусад түүхий эд, өндөг, ургамал, үр, ургамлын гаралтай түүхий эд, зориулалтын хүнсийг импортлох зөвшөөрөл олгоход 350 000 төгрөг.

### **33 дугаар зүйл. Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

33.1. Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



33.1.1.галын аюултай болон тэсэрч дэлбэрэх бодис, материал хадгалах, үйлдвэрлэх, ашиглахад зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгахад 11 000 000 төгрөг;

33.1.2.шатахуун түгээх, борлуулах /шатахуун түгээх станц/ үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

33.1.3.энэ хуулийн 32.1.1-д заасан шаардлагын дагуу галын аюулаас хамгаалах хяналтын албанаас зөвшөөрөл олгоход 180 000 төгрөг;

33.1.4.Галын аюулгүй байдлын тухай хуулийн<sup>31</sup> 16.1.7-д заасны дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад 12 500 төгрөг.

**34 дүгээр зүйл.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

34.1.Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

34.1.1.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах тусгай зөвшөөрөл олгоход 25 000 000 төгрөг;

34.1.2.цөмийн төхөөрөмж ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 15 000 000 төгрөг;

34.1.3.цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 80 000 000 төгрөг;

34.1.4.цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл олгоход 8 500 000 төгрөг;

34.1.5.цацраг идэвхт ашигт малтмал экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх тусгай зөвшөөрөл олгоход 250 000 000 төгрөг;

34.1.6.цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

<sup>31</sup> Галын аюулгүй байдлын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



34.1.7.цацраг идэвхт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход 15 000 000 төгрөг;

34.1.8.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах, ашигт малтмалын боловсруулалтын үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл олгоход 20 000 000 төгрөг;

34.1.9.цацраг идэвхт ашигт малтмалыг импортлохтой холбоотой тусгай зөвшөөрөл олгоход 25 000 000 төгрөг.

34.2.Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

/төгрөгөөр/

Цацрагийн үүсгүүр	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Суманд
Ангилал 1-ийн үүсгүүр	350 000	550 000	650 000
Ангилал 2-ын үүсгүүр	300 000	500 000	600 000
Ангилал 3-ын үүсгүүр	250 000	450 000	550 000
Ангилал 4-ийн үүсгүүр	200 000	400 000	500 000
Ангилал 5-ын үүсгүүр	150 000	350 000	450 000
Рентген тоног төхөөрөмж	100 000	300 000	400 000

**35 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

35.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.1.1.аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 2:50 000 төгрөг;



35.1.2.улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 1 000 000 төгрөг;

35.1.3.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс бусад этгээдэд эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 500 000 төгрөг;

35.1.4.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход Улаанбаатар хотод 250 000 төгрөг, аймагт 150 000 төгрөг.

35.1.5.агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

35.1.6.суманд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

35.1.7.тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

35.1.8.ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 240 000 төгрөг;

35.1.9.ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс доош ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 80 000 төгрөг, гэрээг сунгахад 50 000 төгрөг;

35.1.10.усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад 100 000 төгрөг;

35.1.11.иргэн, хуулийн этгээдэд ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход 120 000 төгрөг;

35.1.12.нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг ашиглахдаа түүнийг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

35.1.13.хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд



тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 20 000 төгрөг;

35.1.14.ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль орчны улсын байцаагч гарал үүслийн гэрчилгээ олгоход 50 000 төгрөг;

35.1.15.үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад 1 000 000 төгрөг;

35.1.16.мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход малын толгой тутмаас 50 төгрөг;

35.1.17.иргэн, хуулийн этгээдэд ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход кг тутамд 20 000 төгрөг;

35.1.18.иргэн, хуулийн этгээдэд элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 1 000 төгрөг;

35.1.19.элбэг ургамлыг гадаадын иргэн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд килограмм тутмаас 10 000 төгрөг;

35.1.20.иргэн, хуулийн этгээдэд ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход ашиглахаар тооцсон хэмжээний килограмм тутамд 50 төгрөг;

35.1.21.мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход Улаанбаатар хотод хуулийн этгээдэд 500 000 төгрөг, иргэнд 250 000 төгрөг, аймагт хуулийн этгээдэд 400 000 төгрөг, иргэнд 200 000 төгрөг;

35.1.22.мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоход 200 000 төгрөг;

35.1.23.мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл



мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 5 000 төгрөг;

35.1.24.рашаан ашиглах, саалах зөвшөөрөл олгоход 320 000 төгрөг.

35.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.2.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг;

35.2.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

35.2.3.согтууруулах ундаагаар шөнийн 00 цаг хүртэл үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000 000 төгрөг.

35.3.Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.3.1.мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход:

	Хураамжийн хэмжээг тооцох нэгж:	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/:
1	6 м <sup>3</sup> хүртэл	1 000
2	6-10 м <sup>3</sup> хүртэл	1 500
3	10-20 м <sup>3</sup> хүртэл	2 000
4	20-60 м <sup>3</sup> хүртэл	5 000

35.3.2.ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:

№	Хураамжийн хэмжээг тооцох нэгж:	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/:
1	8 м <sup>3</sup> хүртэл	1 500
2	8-10м <sup>3</sup> хүртэл	2 000
3	10-20м <sup>3</sup> хүртэл	3 500
4	20-30м <sup>3</sup> хүртэл	5 000



## 35.3.3.ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:

№	Хураамжийн хэмжээг тооцох нэгж:	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/:
1	2 м <sup>3</sup>	300
2	4 м <sup>3</sup>	400
3	6 м <sup>3</sup>	600
4	8 м <sup>3</sup>	800
5	10 м <sup>3</sup>	1 000
6	20 м <sup>3</sup>	1 200
7	30 м <sup>3</sup>	1 500

35.3.4.арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход сийрэг шоо метр тутамд 50 төгрөг;

35.3.5.ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдахад мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход шоо метр тутамд 50 төгрөг.

**36 дугаар зүйл.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтад гэрчилгээ олгох, патентыг болон ашигтай загвар, барааны тэмдгийн бүртгэлийг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

36.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтад гэрчилгээ олгох, патентыг болон ашигтай загвар, барааны тэмдгийн бүртгэлийг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.1.1.шинэ бүтээлд патент олгоход 2 100 төгрөг;

36.1.2.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгоход 1 900 төгрөг;

36.1.3.бүтээгдэхүүний загварт патент олгоход 20 000



төгрөг;

36.1.4.ашигтай загварын гэрчилгээ олгоход 10 000

төгрөг;

36.1.5.шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад:

/хугацаагаар/

№	Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгах хугацаа	Хураамжийн хэмжээ: /төгрөгөөр/
1	эхний 3 жилд	17 600
2	4-6 жилд	31 000
3	7-10 жилд	50 000
4	11-15 жилд	60 000
5	16-20 жилд	70 000

36.1.6.бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад:

/хугацаагаар/

№	Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгах хугацаа	Хураамжийн хэмжээ: /төгрөгөөр/
1	Эхний 2 жилд	13 200
2	3-5 жилд	19 800
3	6-10 жилд	40 000

36.1.7.барааны тэмдгийн хүчинтэй байх хугацааг 10 жилээр дараахь ангиллаар сунгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамжийг хураах:

36.1.7.а.нэг ангилалд сунгахад 2 200 төгрөг;

36.1.7.б.нэгээс дээш ангилалд тус бүрд нэг ангилалд авсан тэмдэгтийн хураамж дээр ангилал тус бүрд нэмж 500 төгрөг;

36.1.7.в.лицензийн гэрээг бүртгэхэд 2 000 төгрөг;

36.1.8.патенттай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөхөд хуудас тутамд 6 000 төгрөг;

36.1.9.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр



ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж зөвшөөрөл олгоход 250 000 төгрөг;

36.1.10.оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага барааны тэмдгийг бүртгэж, гэрчилгээ олгоход 50 000 төгрөг;

36.1.11.барааны тэмдгийн хүчинтэй байх хугацааг сунгахад жил тутамд 5 000 төгрөг;

36.1.12.барааны тэмдэг эзэмших эрхийг бусдад шилжүүлэхэд 95 000 төгрөг;

36.1.13.барааны тэмдгийг бүхэлд нь буюу зарим бараа, үйлчилгээний хувьд ашиглах лицензийн гэрээ байгуулж бүртгүүлэхэд 50 000 төгрөг;

36.1.14.оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгох, хугацааг сунгахад жил тутамд 20 000 төгрөг;

36.1.15.технологи дамжуулах, технологи ашиглах тухай гэрээг бүртгэж, лиценз олгоход 50 000 төгрөг.

### **37 дугаар зүйл.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

37.1.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

37.1.1.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөл олгоход 345 000 төгрөг;

37.1.2.зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэж, гэрчилгээ олгоход бүтээл тус бүрд 600 төгрөг;

37.1.3.энэ хуулийн 37.1.2-т заасан бүртгэлд өөрчлөлт оруулахад 220 төгрөг;

37.1.4.зохиогчийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөхөд хуудас бүрээс 150 төгрөг;

37.1.5.тодорхой бүтээлийн зохиогчийн эрхийг өөрийн



болон гадаад оронд төлөөлөн хамгаалах зөвшөөрөл олгоход 150 000 төгрөг;

37.1.6.нийтийн эзэмшлийн барилга, байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг.

**38 дугаар зүйл.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

38.1.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл хийх үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

38.1.1.шинээр бий болсон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг түүний шинээр бий болсныг нотлох баримт бичгийг үндэслэн бүртгэхэд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлд тусгах үнийн 0.01 хувиар;

38.1.2.баригдаж дуусаагүй барилга, байгууламж өмчлөх эрхийг газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг үндэслэн, иргэний өмчийн газар дээр баригдаж байгаа бол газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тухайн газрыг өмчлөгч иргэний зөвшөөрлийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд 25 000 төгрөг;

38.1.3.төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан газар болон орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулахад 4 000 төгрөг;

38.1.4.эрхийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулахад:

Нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл	Өмчлөх эрхийг шилжүүлж байгаа гэрээний үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
Үл хөдлөх эд хөрөнгө гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжихэд	10 000 000 хүртэл	Үнийн дүнгийн 0.01 хувиар
	10 000 001-100 000 000	Үнийн дүнгийн 0.02 хувиар
	100 000 000—аас дээш бол	0.015 хувиар





Эрх бүхий байгууллагын шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх	Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран	30 000
Үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, оршин байгаа газрын харьяалал өөрчлөгдөх	Эд хөрөнгийн үнэ, хэмжээ, зориулалтаас үл хамааран	8 000

38.1.5.эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл, урьдчилсан тэмдэглэл хийхэд 1 500 төгрөг;

38.1.6.гэрээг сунгасан, цуцалсан, дуусгавар болсныг бүртгэх, энэ хуулийн 38.1.5-д заасан урьдчилсан тэмдэглэл, тусгай тэмдэглэлийг хүчингүй болгоход 1 500 төгрөг;

38.1.7.дундаа хэсгээр өмчлөх үл хөдлөх эд хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөх эрхийг өөр этгээдэд шилжсэнийг бүртгэхэд 6 500 төгрөг;

38.1.8.ипотек өөр этгээдэд шилжсэнийг бүртгэхэд 8 200 төгрөг;

38.1.9.ипотек өмчлөгчид шилжсэнийг бүртгэхэд 6 600 төгрөг;

38.1.10.ипотекоор хангагдах шаардлагыг өөр шаардлагаар сольсныг бүртгэхэд 5 000 төгрөг;

38.1.11.ипотек дуусгавар болсныг бүртгэхэд 3 000 төгрөг;

38.1.12.үл хөдлөх эд хөрөнгө түрээслэсэнийг бүртгэхэд 8 000 төгрөг;

38.1.13.сервитутыг бүртгэхэд гэрээнд оролцогч талууд тус бүрээс 17 500 төгрөг;

38.1.14.узуфруктыг бүртгэхэд гэрээнд оролцогч талууд тус бүрээс 25 000 төгрөг;

38.1.15.бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд 55 000 төгрөг;

38.1.16.газар эзэмших, ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд га тутамд 15 000 төгрөг;



38.1.17.Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн<sup>32</sup> 6.5-д заасны дагуу дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан лавлагаа өгөхөд 3 000 төгрөг;

8.1.18.эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд хүчингүй болгож, нөхөн олгоход 45 000 төгрөг;

38.1.19.эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг гэмтээсэн тохиолдолд түүнийг хүчингүй болгож, нөхөн олгоход 8 000 төгрөг;

38.1.20.эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл, хувийн хэргийг хаахад 3 600 төгрөг;

38.1.21.Иргэний хуулийн<sup>33</sup> 182.2, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3.7-д зааснаар хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд тухайн эд хөрөнгийн эрхийн бүртгэлд тусгасан үнийн дүнгийн 0.1 хувиар.

**39 дүгээр зүйл.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

39.1.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

39.1.1.иргэнд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинээр олгоход нийслэлд 20 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 10 000 төгрөг, бусад суманд 6 000 төгрөг;

39.1.2.аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг шинээр олгоход нийслэлд 70 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 20 000 төгрөг, бусад суманд 10 000 төгрөг;

<sup>32</sup> Эд хөрөнгийн өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>33</sup> Иргэний хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



39.1.3.иргэн газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхэд нийслэлд 20 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 10 000 төгрөг, бусад суманд 6 000 төгрөг;

39.1.4.аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхэд нийслэлд 70 000 төгрөг, аймгийн төвийн сум, нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт 20 000 төгрөг, бусад суманд 10 000 төгрөг;

39.1.5.газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгахад иргэнээс 6 000 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагаас 12 000 төгрөг;

39.1.6.газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулах баримт бичиг хүлээн авахад 12 500 төгрөг;

39.1.7.геологийн судалгаа хийх зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгоход 70 000 төгрөг;

39.1.8.ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгоход 1 000 000 төгрөг;

39.1.9.ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглуулахаар газрын хэвлийг олгоход 70 000 төгрөг;

39.1.10.Улсын Их Хурлаас гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессийн гэрээгээр ашиглуулахаар шийдвэрлэж, зөвшөөрөл олгоход м<sup>2</sup> тутамд 2 000 төгрөг;

39.1.11.дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэр гаргаж зөвшөөрөл олгоход м<sup>2</sup> тутамд 2 500 төгрөг;

39.1.12.газар эзэмшигч нь эрхийн гэрчилгээг Иргэний хуульд нийцүүлэн барьцаалсан тухай сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэхэд 10 000 төгрөг;



39.1.13.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл олгоход 950 000 төгрөг.

**40 дүгээр зүйл.Баримт бичиг баталгаажуулж, "Апостиль"  
гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн  
хэмжээ**

40.1.Гадаадын албан ёсны баримт бичгийг баталгаажуулах шаардлагыг халах тухай конвенцийн гишүүн улсад хэрэглэгдэх дотоодын албан ёсны баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулж, "Апостиль" гэрчилгээ олгоход 20 000 төгрөгийн хураамж хураана.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**41 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх**

41.1.Шүүхэд гаргасан дараахь нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө:

41.1.1.тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;

41.1.2.патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;

41.1.3.төсвийн байгууллагын нэхэмжлэл;

41.1.4.төсөвт төлөх албан татвар, хураамж, төлбөр, торгууль, хүү, алдангийг төлүүлэх талаар гаргасан нэхэмжлэл;

41.1.5.гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл;

41.1.6.шүүхийн зардал төлөх хөрөнгөгүйн улмаас шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл;

41.1.7.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулахаар гаргасан нэхэмжлэл;

41.1.8.цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй



холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл;

41.1.9.хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан шийтгэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авсны улмаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл;

41.1.10.хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авсан тохиолдолд нөхөн олговор, үнийг төлүүлэхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл;

41.1.11.Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан нэхэмжлэл;

41.1.12.төлбөрийн чадваргүй болсон банкинд томилогдсон банкны бүрэн эрхт төлөөлөгч, банкны эрх хүлээн авагчаас гаргасан нэхэмжлэл.

41.2.Шүүх хуульд заасны дагуу өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан тэмдэгтийн хураамж төлөх хугацааг хойшлуулж, түүнийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх буюу хураамжийн хэмжээг ихэсгэх, багасгах, буцаан олгоходоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай<sup>34</sup> хуулийн 57-59 дүгээр зүйлд заасныг үндэслэл болгоно.

41.3.Дараахь нөхцөлд гадаадын иргэнд олгох визийн хураамжийг чөлөөлөх буюу хөнгөлнө:

41.3.1. 5-10 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг жуулчны визийн хураамжийн хэмжээг 25 хувиар хөнгөлөх;

41.3.2. 10-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй бүлэг жуулчны визийн хураамжийн хэмжээг 50 хувиар хөнгөлөх;

41.3.3.харилцан адил байх зарчим баримтлан дипломат ангиллын виз олгох болон гадаад улсын төрийн өндөр хэмжээний айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд орж байгаа хүнд олгох визийн хураамжийг чөлөөлөх;

41.3.4.гадаад орны төр, засгийн албан тушаалтанд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төлөөний нотоор виз олгох хүсэлт тавьсан тохиолдолд визийн хураамжаас чөлөөлөх;

<sup>34</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.



41.3.5.Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу визийн хураамжаас чөлөөлөхөөр тохиролцсон бол хэлэлцээрийн дагуу гадаадын иргэнийг визийн хураамжаас чөлөөлөх;

41.3.6.Монгол Улсын иргэний гадаад улсын харьяатаар төрсөн 16 хүртэлх насны хүүхдийг визийн хураамжаас чөлөөлөх;

41.3.7.гадаад улсаас Монгол Улсад суугаа өргөмжит консул, түүний гэр бүлийн гишүүнийг визийн хураамжаас чөлөөлөх;

41.3.8.Монгол Улсын харьяатаас гарч гадаад улсын харьяат болсон гадаадын иргэнийг визийн хураамжаас чөлөөлөх.

41.4.Дараахь үйлчилгээг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө:

41.4.1.давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр үрэгдсэн, гэмтсэн баримт бичгийг дахин олгох, магадлагаа, лавлагаа гаргах;

41.4.2.улсын болон бусдын эрх ашгийг хамгаалах, иргэний үүргээ биелүүлэх, хууль ёс сахиулах, бусдын амь насыг аврах үйл ажиллагааны улмаас амь үрэгдсэн иргэний хөрөнгийн талаар өвлөгчид гэрчилгээ олгох;

41.4.3.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй холбогдсон иргэний бүртгэлийн баримт бичигт тэмдэглэл хийх;

41.4.4.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилсэн хүүхэд, эцэг, эхэд эд хөрөнгө болон хадгаламжийн дансанд байгаа мөнгийг өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох;

41.4.5.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн<sup>28</sup> 4.1.1-д заасны дагуу иргэн гэр бүлийнхээ хэрэгцээний зориулалтаар өмчлөн авсан газрын өмчлөх эрхийг бүртгүүлэх;

41.4.6.төрийн байгууллагад хэрэглэгдэж байгаа холбоонд зориулан радио долгионы зөвшөөрөл олгох;

41.4.7.мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага байгуулах;

<sup>28</sup> Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



41.4.8.батлан хамгаалах хэрэгцээний газрын зөвшөөрөл олгох;

41.4.9.биеийн давхцахгүй өгөгдлийг /гар, хурууны хээ/ бүртгэх;

41.4.10.Монгол Улсад Засгийн газар хоорондын гэрээгээр суралцах, ажил, албан тушаал эрхлэх, гадаадын төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдах бүрэлдэхүүнд ажиллах болон түүнтэй адилтгах албан тушаал эрхлэхээр 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэний албан хэргээр удаан хугацаагаар оршин суугчийн бүртгэлийн хураамж;

41.4.11.гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газар ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг Монгол Улсад ирсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэхэд хураах тэмдэгтийн хураамж;

41.4.12.мэргэжлийн болон шинэжлэх ухааны байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох.

## **42 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамж төлөх журам, түүнд хяналт тавих**

42.1.Тэмдэгтийн хураамжийг энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлж байгаа эрх бүхий байгууллага бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хураах бөгөөд хураамж авах албан тушаалтныг байгууллагын эрх баригчийн шийдвэрээр томилон ажиллуулна.

42.2.Шүүхэд нэхэмжлэл гаргагч тэмдэгтийн хураамжийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлж, энэ тухай баримтыг нэхэмжлэлийн хамт ирүүлнэ.

42.3.Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.



42.4.Энэ хуулийн биелэлтэд Үндэсний татварын алба хяналт тавина.

#### **43 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамжийн тайлан гаргах**

43.1.Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд гаргаж өгнө.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан татварын алба нь тэмдэгтийн хураамжийн тайланг нэгтгэн, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

43.3.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 43.2-т заасан тайланг хянаж, 3 дугаар сарын 05-ны дотор тэмдэгтийн хураамжийн улсын нэгдсэн тайланг гаргана.

#### **44 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжийг буцаан олгох**

44.1.Тэмдэгтийн хураамжийг дараахь тохиолдолд буцаан олгоно:

44.1.1.тогтоосон хэмжээнээс илүү хураасан;

44.1.2.энэ хуульд чөлөөлөхөөр заасан үйлчилгээнээс хураасан;

44.1.3.үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан;

44.1.4.данс андуурагдсанаас өөр төрлийн төлбөр хийгдсэн.

#### **45 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамжийн талаар гомдол гаргах**

45.1.Иргэн, хуулийн этгээд нь тэмдэгтийн хураамжтай холбогдсон гомдлоо тэмдэгтийн хураамж төлснөөс хойш 14 хоногийн дотор эрх бүхий байгууллага болон шүүхэд гаргах эрхтэй бөгөөд уг гомдлыг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.





45.2.Шүүхээс хураасан тэмдэгтийн хураамжийн талаар гарсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу дээд шатны шүүх нь хянан шийдвэрлэнэ.

#### **46 дугаар зүйл.Тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

46.1.Тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, улсын байцаагч дараахь хариуцлага хүлээлгэнэ:

46.1.1.хуульд заасан тэмдэгтийн хураамжийг хураагаагүй буюу дутуу хураасан, хураасан боловч төсөвт төлөөгүй бол Татварын ерөнхий хуулийн 74.1, 74.3-т заасан хариуцлага;

46.1.2.тэмдэгтийн хураамжийн орлогыг хугацаанд нь улсын болон орон нутгийн төсөвт төлөөгүй бол Татварын ерөнхий хуулийн 74.2, 74.3-т заасан хариуцлага.

46.2.Тэмдэгтийн хураамжийн тухай хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид Татварын ерөнхий хуулийн 75 дугаар зүйлд заасан захиргааны хариуцлага ногдуулна.

46.3.Хуулиар тэмдэгтийн хураамж хураах эрхгүй байгууллага, хувь хүн, албан тушаалтан хураамж хураасан, эсхүл хураамж хураах эрх бүхий байгууллага, хувь хүн, албан тушаалтан энэ хуульд заагаагүй үйлчилгээ үзүүлж, хураамж авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын алба, татварын улсын байцаагч хууль бусаар олсон орлогыг хурааж, байгууллага, хувь хүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

#### **47 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

47.1. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ЦАРГА**

**Н.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2010 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 258

Улаанбаатар  
хот**Прокурорын мэргэжлийн зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 264 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралтыг хүчвэгүйд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн  
258 дугаар зарлигийн хавсралт

**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН****Зөвлөлийн дарга**

Ц.Бямбацогт -Улсын ерөнхий прокурорын орлогч

**Зөвлөлийн гишүүд:**

1. С.Нямжав -Улсын дээд шүүхийн шүүгч

2. Г.Эрдэнэбат - Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан туслах

3. Ж.Бямбаа – МУИС-ийн ХЗС-ийн эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор



4. Ж.Энхнасан – Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч

5. Г.Бахдал – Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч

6. Улсын ерөнхий прокурорын туслах, Мэдээлэл, дүн шинжилгээ, бодлого төлөвлөлт хариуцсан /албан тушаалаар/

7. Улсын ерөнхий прокурорын туслах, Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт хариуцсан /албан тушаалаар/

8. Улсын ерөнхий прокурорын туслах, Шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан /албан тушаалаар/

9. Улсын ерөнхий прокурорын туслах, Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт хариуцсан /албан тушаалаар/

10. Улсын ерөнхий прокурорын туслах, Гүйцэтгэх ажилд тавих хяналт хариуцсан /албан тушаалаар/

11. Улсын ерөнхий прокурорын туслах, Тамгын хэлтсийн дарга /албан тушаалаар/

12. Нийслэлийн прокурор /албан тушаалаар/

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 9 дүгээр  
сарын 5-ны өдөр

Дугаар 237

Улаанбаатар  
хот

### Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ"-г хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2003 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 213 дугаар тогтоол, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Журамд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 63 дугаар тогтоол, Засгийн газрын 2006 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ын 2.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг баталсан шийдвэрээ хүчингүй болсонд тооцохыг Засгийн газрын гишүүд, аймгийн Засаг дарга нарт даалгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоолыг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АПТАНХУЯГ**

**Засгийн газрын 2010 оны 237 дугаар  
тогтоолын хавсралт**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

Нэг. Иргэний бүртгэлийн үйлчилгээ

1.1. Төрсөн иргэнийг бүртгэх -үнэ төлбөргүй

1.2. Иргэний байдлын бүртгэл хийх -2500 төгрөг

-гэрлэлтийг бүртгэх;

-гэрлэлт цуцалсныг бүртгэх;



- гэрлэлт сэргээснийг бүртгэх;
- хүүхэд үрчилснийг бүртгэх;
- эцэг тогтоосныг бүртгэх;
- овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг бүртгэх.

1.3. Нас барсныг бүртгэх -үнэ төлбөргүй.

1.4. Иргэний бүртгэлийн гэрчилгээ дахин олгох -5000 төгрөг.

1.5. Нийслэлээс аймагт, аймгаас аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх -2500 төгрөг.

1.6. Аймгаас нийслэлд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх -5000 төгрөг.

1.7. Аймаг, нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх -1500 төгрөг.

1.8. 16 нас хүрээгүй хүүхдийн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх -үнэ төлбөргүй.

1.9. Түр шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэж, оршин суух үнэмлэх олгох -2500 төгрөг.

#### Хоёр. Иргэний үнэмлэх олгох үйлчилгээ

2.1. Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, дахин олгох -10000 төгрөг.

#### Гурав. Архивын үйлчилгээ

3.1. Улсын бүртгэлийн хураангуй лавлагаа олгох -1000 төгрөг.

3.2. Улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа олгох -5000 төгрөг.

3.3. Архивын баримтаас иргэний бүртгэлийн хуулбар хийж, олгох (хуудас тутам) -200 төгрөг.

3.4. Архивын баримтаас эд хөрөнгийн, хуулийн этгээдийн бүртгэлийн хуулбар хийж олгох (хуудас тутам) -500 төгрөг.



3.5. Улсын бүртгэлийн архивын лавлагааны хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч лавлагаа олгох -800 төгрөг.

Дөрөв. Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн үйлчилгээ

4.1. Үндэсний энгийн гадаад паспорт 1 жилээр олгох -17500 төгрөг.

4.2. Үндэсний энгийн гадаад паспорт 5 жилээр олгох -27500 төгрөг.

4.3. Үндэсний энгийн гадаад паспортын хугацааг сунгах:

-1 жил -2000 төгрөг;

-2 жил -4000 төгрөг;

-3 жил -6000 төгрөг;

-4 жил -8000 төгрөг;

-5 жил -10000 төгрөг.

4.4. Үндэсний энгийн гадаад паспортыг гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан олгох (5 жилээр) -18500 төгрөг.

4.5. Үндэсний энгийн гадаад паспортыг х чингүй болгох -үнэ төлбөргүй.

4.6. Дипломат, албан паспорт олгох -17500 төгрөг.

4.7. Дипломат, албан паспортын хугацааг сунгах (1-5 жилээр) - 5100 төгрөг.

4.8. Гадаад паспортанд хавсаргагдах үнэмлэх (хүүхдийн) олгох - 3000 төгрөг.

4.9. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн үндэсний энгийн гадаад паспортанд хүүхдийн зургийг нааж баталгаажуулах -3000 төгрөг.

4.10. Хил орчмын нутагт зорчих нэг удаагийн үнэмлэх олгох -3000 төгрөг.



4.11. Хил орчмын нутагт зорчих олон удаагийн үнэмлэх олгох -10000 төгрөг.

4.12. Оросын Холбооны Улсад визгүй зорчих хуудас олгох -1000 төгрөг.

4.13. Буцах үнэмлэх олгох -35000 төгрөг.

Тав. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн  
үйлчилгээ

5.1. Үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа улсын бүртгэлд бүртгэх -үнэ төлбөргүй.

5.2. Төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан газар өмчлөх эрхийг баталгаажуулах -үнэ төлбөргүй.

5.3. Төрөөс үнэ төлбөргүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг баталгаажуулах -5000 төгрөг.

5.4. Эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх -эрхийн бүртгэлд тусгасан дүнгийн 1 хувь.

5.5. Эд хөрөнгийн өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх -20000 төгрөг:

-худалдах, худалдан авах гэрээ;

-бэлэглэлийн гэрээ;

-арилжааны гэрээ;

-өв залгамжлах эрх;

-шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх;

-албадан дуудлага худалдаагаар худалдах, худалдан авах гэрээ.

5.6. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах -8000 төгрөг:

-өмчлөгчийн хүсэлтээр бүртгэлд нэмэлт өөрчлөлт, залруулга хийх;

- хамтран өмчлөгч нэмэгдэх, хасагдах;
- эд хөрөнгийн хаяг, хэмжээ өөрчлөгдөх;
- эд хөрөнгийг салгах, нэгтгэх.

5.7. Эд хөрөнгийн барьцаа (ипотек) болон батлан даалтын гэрээний эрхийг улсын бүртгэлд бүртгэх -барьцаагаар хангагдах үнийн дүнгийн 0.05 хувь.

5.8. Барьцаалбар бүртгэх -3000 төгрөг.

5.9. Гэрээнд өөрчлөлт орох, сунгахыг бүртгэх -5000 төгрөг.

5.10. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрээг дуусгавар болгох, цуцлах -үнэ төлбөргүй.

5.11. Өмчлөх эрхтэй холбоотой бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэх -10000 төгрөг:

- түрээсийн гэрээ;
- сервитут;
- узуфрукт;
- санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээ;
- бусдын газар дээр барилга, байгуул амж барих эрх;
- газар эзэмших, ашиглах эрх.

5.12. Эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл, урьдчилсан тэмдэглэл хийх -5000 төгрөг.

5.13. Эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэл, урьдчилсан тэмдэглэлийг хүчингүй болгох -үнэ төлбөргүй.

5.14. Эд хөрөнгө өмчлөх эрхийн гэмтээсэн гэрчилгээг дахин олгох -20000 төгрөг.

5.15. Эд хөрөнгө өмчлөх эрхийн үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөн олгох -20000 төгрөг.



5.16. Эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн хувийн хэрэг хаах - үнэ төлбөргүй.

Зургаа. Хуулийн этгээдийн бүртгэлийн  
үйлчилгээ

6.1. Хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах -500 төгрөг.

6.2. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээ олгох -5000 төгрөг.

Долоо. Яаралтай үйлчилгээ

7.1. Иргэний үнэмлэх яаралтай олгох үйлчилгээг ажлын 7 өдөр, үндэсний энгийн гадаад паспорт яаралтай олгох үйлчилгээг ажлын 3 өдөр багтаан үзүүлнэ. Бусад яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаан үзүүлнэ.

7.2. Яаралтай үйлчилгээнд энэ хавсралтын 1.1-1.9, 3.3-3.5, 4.3-4.13, 5.1, 5.2, 5.4, 5.14, 5.15, 6.1-д заасан үйлчилгээ хамаарахгүй.

7.3. Яаралтай үйлчилгээ үзүүлэхэд үйлчилгээний хөлсний хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.

7.4. Гадаад паспорт олгох яаралтай үйлчилгээний хөлс -10000 төгрөг байна.

Тайлбар: Гадаадад суугаа Дипломат болон Консулын төлөөлөгчийн газраас үзүүлэх үйлчилгээний хөлсийг тухайн өдрийн Монголбанкны ханшаар чөлөөт валютад хөрвүүлэн тооцож болно.

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмгэгчийн редакци.


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 4/5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэн.

Үгс 329487